

ДАЛТЫН ХАДНЫ ЗУРАГ, ЭРТНИЙ БИЧЭЭС (УРЬДЧИЛСАН СУДАЛГАА)

М.ЭРДЭНЭ¹, Ц.БАТТУЛГА²

¹МУИС, НШУС, Археологи-Антропологийн тэнхим, e-mail: merdene@num.edu.mn

²МУИС, ГХСС, Түрэг судлалын тэнхим, e-mail: ts_battulga@yahoo.com

Түлхүүр үг: Баянхонгор аймаг, Бөмбөгөр сум, Далт, Хадны зураг, янгир, аргаль, бугын дүрслэл, руни бичиг

ТОВЧ АГУУЛГА: Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын нутаг Далт уулын наран ээвэр энгэрт байх хаднаа 100 гаруй дүрслэлтэй хадны зураг, эртний руни бичээс археологийн хайгуулын явцад олдсоныг шинжлэх ухааны эргэлтэд оруулах зорилгоор нийтлүүлж байна. Уг хадны зураг дахь амьтдын дүрслэл, тэдгээрийг урласан арга барилаас нь харвал эдгээр сүг зургууд нь хүрэл зэвсгийн үеэс төмрийн түрүү хүртэл үед холбогдох ажээ. Түүнчлэн уг хаднаа үлдээсэн эртний түрэг бичээсийг Энэхүү өгүүллээр Баянтүмбийн хадны зургийг олны хүртээр болгож шинжлэх ухааны эргэлтэнд оруулахыг зорив.

Монгол Улсын "Соёлын Өвийг хамгаалах тухай" хуулийн 6-р бүлгийн 17-гийн 10-т “Хот суурин, барилга байгууламж барих шинээр зам тавих, Усан цахилгаан станц барих, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгоход түүх, археологийн мэргэжлийн байгууллагаар хайгуул судалгаа хийлгэж зөвшөөрөл авна” гэж заасан байдаг билээ. Энэхүү заалтын дагуу Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын нутагт буй “Том шижир” ХХК-ий “Далт” XV-013210 (818 га), XV – 016924 (698 га), MV – 016923 (243га) тусгай зөвшөөрөл бүхий нийт 1760 га талбайд археологийн авран хамгаалах хайгуул судалгаа хийсэн болно.

Судалгааны ажлын гол зорилго нь чулуун зэвсгийн бууц, эртний булш, хот суурин ба хадны сүг зураг, хөшөө болон бусад төрлийн археологи, түүхийн дурсгалуудыг илрүүлэх, илрүүлсэн эртний дурсгалуудын байршлын газар зүйн солбицлыг тогтоох, дурсгалын төрөл, хэлбэр, хэмжээ, түүхэн он цагийг тодорхойлох, гэрэл зураг авч баримтжуулах, шинжлэх ухааны ач холбогдлыг нь тодорхойлоход оршиж байсан болно.

Хээрийн судалгааны ажлын зарим үр дүнг шинжлэх ухааны эргэлтэд оруулах зорилгоор нийтлүүлж буй бөгөөд бид энэ удаад хадны зураг, руни бичгийн дурсгалын талаар тухайлан өгүүлэхийг хичээлээ.

БАЯНХОНГОР АЙМГИЙН НУТАГ ДАХЬ АРХЕОЛОГИЙН ДУРСГАЛЫН СУДЛАГДСАН БАЙДАЛ

Баянхонгор аймгийн нутаг монголын түүх соёлын дурсгалаар нэн баялаг бөгөөд археологийн судалгаагаар уг аймгийн нутагт чулуун зэвсэг, хүрэл, хүннү, түрэг, дундад зууны үед хамаарах булш оршуулгын болон хот суурингийн дурсгалууд, буган хөшөө, хүн чулуу, хадны зураг, эртний бичээсүүдийг олноор илрүүлэн судлан шинжилжээ. Эдгээр дурсгалаас заримыг дор авч үзье.

Баянхонгор аймгийн нутагт чулуун зэвсгийн олон дурсгалт газар, бууц суурингууд илрүүлэн судалсан байдаг. Тухайлбал, 1985 онд МЗТСХЭ Баянхонгор аймгийн Баянлиг сумын нутагт орших Зуухын шинэ чулуун зэвсгийн сууринг анх илрүүлэн олсон бөгөөд 1985, 1995 онд явуулсан судалгаагаар эндээс археологийн дурсгал бүхий дөрвөн суурин газар олдсоны нэг нь хуучин чулуун зэвсгийн дээд үеийн, хоёр нь шинэ чулуун зэвсгийн үеийн, нэг нь хүрэл зэвсгийн түрүү үеийн дурсгалтай байжээ (Деревянко и др., 1986; Гүнчинсүрэн, 1995).

Мөн 1986 онд Монгол, Зөвлөлтийн археологичид Өлзийт сумын нутаг Уран хайрхан уулын орчмын Нарийн голын хөндийгөөс доод палеолитын үед хамаарах чулуун зэвсгийн дурсгалт газрыг илрүүлэн судалсан байна (Дорж, 1990).

Монголын чулуун зэвсгийн үеийн судалгааны түүхэнд шинэ хуудас нээсэн дурсгал бол Баянхонгор аймгийн Баянлиг сумын нутаг дахь Цагаан агуйн хуучин чулуун зэвсгийн үеийн дурсгал юм. Монгол, Орос, Америкийн археологичид 1987, 1989, 1995-1998 онд уг агуйд малтлага судалгаа хийсэн ба судалгааны үр дүнд Монгол нутагт хүн 700 000 жилийн тэртээгээс суурьшин амьдарч байсныг тогтоожээ (Деревянко и др., 1996). Үүнээс гадна Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын нутаг Чихэн уул гэдэг багавтар уулнаа орших шохойн чулуулгийн агуйг анх 1987 онд МЗТСХЭ-ийн А.П.Деревянко, Д.Дорж нарын удирдсан шинжилгээний анги илрүүлэн олсон бөгөөд 1995 оноос Монгол-Орос-Америкийн археологийн хамтарсан экспедиц малтан судалж уг чулуун зэвсгийн суурин нь дунд палеолитын төгсгөлөөс мезолит, неолитын үеийн, өөрөөр хэлбэл, чулуун зэвсэг үйлдвэрлэлийн гурван үеийн дурсгалыг хадгалсан, урт удаан хугацааны турш эртний хүн амьдарч байсан томоохон дурсгалт газар болохыг тогтоожээ (Деревянко и др., 1998).

Баянхонгор аймгийн нутагт олноор олддог өөр нэг дурсгал бол хадны зураг юм. Баянлиг сумын нутаг Их Баян уулын Бичигтийн амны хаданд сийлсэн зургийг Н.Сэр-Оджав судлан уг хаданд хүрэл зэвсгийн үеэс дундад эртний үе буюу манай эриний наймдугаар зууныг хүртэл түүхийн олон үеийн турш эртний хүмүүсийн үлдээсэн сүг зураг байгааг тодорхойлжээ (Сэр-Оджав, 1987). Бичигтийн амны хаданд сийлбэрлэсэн зургууд ан амьтан, аж ахуй, дайн байлдаан зэрэг олон сэдвийг хамарсан байдаг ба дүрслэлийн тоо хэмжээ, илэрхийлсэн сэдэв, зохиомж, дүрслэх арга барил, уран сэтгэмж зэрэг чанараараа Монголын төдийгүй Төв Азийн бүс нутагт эрдэм шинжилгээний чухал ач холбогдол бүхий дурсгал болох юм.

Жаргалант сумын нутаг Шанх ууланд орших Бугат хэмээх цохионы хадны зураг судлаачдын анхаарлыг татдаг. Энэ хаданд зургаан буга, нэг янгирыг дүрслэхдээ амьтны дүрсийг бүх талбайгаар нь хонхойлгон цохих, гадна талаар нь хөвөөлөн цохих хоёр арга барилыг хэрэглэсэн байхаас гадна амьтныг бодит байдлаар болон загварчлан дүрслэх аргыг бас хослуулжээ (Цэвээндорж, 1979).

Бууцагаан сумын нутаг Гурван мандал уулын оройн тэгш толигор хаднуудаар олон үеийн хүмүүсийн бүтээл хадны сүг зураг, тамга тэмдгийн зүйл ихээр дүрслэгдсэн байдаг. Эдгээр дүрсийг нэлэнхүйд нь хонхойлон цохихоос гадна нарийн үзүүртэй зүйлээр сараачин дүрслэх хоёр аргыг хэрэглэжээ (Баяр, 1996).

Баян-Өндөр сумын нутагт Чихэн агуйгаас баруун тийш 2 орчим км-т орших Саальтын агуйд дөрвөн хэсэг зосон зураг дүрслэгдсэн байдаг. Эдгээрийг судлаачид дүрслэл, зурсан арга барил, будаг хадгалагдан үлдсэн байдал зэргээр нь Өмнөд Сибирь, Өвөр Байгал орчмын дурсгалуудтай харьцуулан авч үзээд хүрэл зэвсгийн сүүл үед хамаарна гэсэн бол зарим судлаачид шинэ чулуун зэвсгийн үед холбогдоно хэмээн үзжээ (Деревянко и др., 1998).

Хожим 1995 оноос Монгол-Орос-Америкийн хамтарсан “Монголын чулуун зэвсгийн үе” экспедиц үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш уг экспедиц дан ганц чулуун зэвсгийн хайгуул судалгаа, малтлагын ажил төдийгүй мөн хадны зургийн хайгуул тандалтын ажлыг давхар гүйцэтгэж Баянлиг сумын нутаг Хар уул, Цагаан агуй, Баян-Өндөр сумын Саальтын агуй, Шинэжинст сумын Цагаан хаалга, Сонгинот, Гэцэлийн ус зэрэг газраас урьд өмнө олдож судлагдаагүй шинэ сонирхолтой дурсгалуудыг илрүүлэн олсон байна. Түүнчлэн Баянлиг сумын нутаг Их Баян уулын Бичигтийн амны хадны зургийг дахин нарийвчлан судлах явцад шинэ сонирхолтой зургуудыг нэмэн илрүүлжээ (Цэвээндорж, Цэрэндагва, 2005).

Баянхонгор аймгийн нутагт байх алдартай дурсгалуудын нэг бол Шатар чулууны цогцолбор дурсгалт газар юм. Эрдэнэцогт сумын нутаг, Түйн голын зүүн талд урдаас орж ирсэн амыг Шатар чулуу гэх бөгөөд энэ аманд хадны сүг зураг, дөрвөлжин булш, дөрвөлжин болон дугуй хүрээтэй хиригсүүрүүд, шоргоолжин булш, цагираг хэлбэрийн булш, буган хөшөө, хүн чулуун хөшөө, зэл чулуу, чулуун арслан зэрэг түүхийн олон үед хамаарах 50 гаруй дурсгал оршдог. Судлаачид энд орших буган чулуу, хүн чулуут хашлага зэргийг судалснаас гадна зарим булшийг малтан шинжилжээ. Шатар чулуун дах дүгрэг хэлбэртэй гурван булшийг малтахад хөлийг агийлган, шарилын дээгүүр улаан зос будаг цацсан оршуулга гарсныг судлаачид булшны гадаад хэлбэр хийгээд, оршуулгын зан үйлээр Оросын Алтайд шинжилсэн МЭӨ III – II зууны үед холбогдох “Афанасьевийн соёл” хэмээн нэрлэгдэх хүрэл зэвсгийн эхэн үеийн дурсгалтай холбон авч үзжээ (Волков, 1980).

Баянхонгор аймгийн нутагт эртний Түрэгийн үеийн дурсгал олон байдаг. Тэдгээрийн нэг Заг сумын нутаг Бумбатын ам хэмээх газар орших Түрэгийн үеийн хүн чулуут тахилын хоёр онгоныг судлаачид бүртгэн хэвлүүлсэн байдаг (Монгол нутаг дахь ..., 1999). Үүнээс гадна 2005 онд Монгол-Италийн хамтарсан “Говийн

гео-археологи” төслийн хүрээнд Баянхонгор аймгийн Богд сумын нутаг Их Богд уулын зүүн хойд бэлд буй Цагаан өвдөг, Зэрэглээн бэл, Тарималт зэрэг газруудад нийт 8 булш малтсаны хоёр нь эртний Түрэгийн үед хамаарах булш байжээ (Гүнчинсүрэн ба бусад, 2005). Мөн уг төслийн судлаачид Богд сумын нутагт Их Богд уулын ар бэл, Орог нуурын өмнөд хөвөө орчмоор хайгуул хийн хүрэл зэвсгийн үеийн 250 гаруй булш, хиригсүүр бүхий оршуулгын дурсгалт газрыг илрүүлж, дэвсгэр зургийг хийсэн байна (Гүнчинсүрэн ба бусад, 2006). Мөн Их Богд уулын Зэрэглээн бэл, Цагаан өвдөг, Тарималт, Бөгсийн гээг болон Густын ам зэрэг газар 20 гаруй булш малтан судалж он цагийг тогтоожээ (Гүнчинсүрэн нар 2010).

Монголын эртний нүүдэлчдийн оршуулгын зан үйлийн нэгэн өвөрмөц хэлбэр болох хадны буюу агуйн оршуулга манай улсын уулархаг нутгаас, тэр дундаа Баянхонгор аймгаас олдсон хэд хэдэн тохиолдол байдаг. Археологийн хүрээлэнгийн судлаачид орон нутгийн иргэдийн мэдээллээр 2010 онд ийм хэлбэрийн булш Бөмбөгөр сумын нутагт гурав, Заг сумын нутагт нэгийг авран хамгаалах малтлага хийжээ. Бөмбөгөр сумын Улаансайр багийн нутаг Маанийн хөндийд орших Ёдортын хад, Заг сумын нутаг Хойд Дэл уулын Оорцогийн агуй, Бөмбөгөр сумын нутаг Дэлийн үзүүр зэрэг газраас эдгээр оршуулгуудыг олсон бөгөөд харамсалтай нь судлаачдыг очиж судлах үед Ёдортын оршуулгаас бусад нь эвдэгдэн сүйдсэн, олдворуудыг гарган тараан хаясан байдалтай байжээ. Эдгээр оршуулгуудын эд өлөгийн зүйлс дундад зууны үеийн монголчуудын зан заншил, хувцас хэрэглэлийг нэхэн судлахад үнэтэй хэрэглэгдхүүн болж байна (Хүрэлсүх ба бусад, 2011).

Харин эртний бичиг дурсгалын цөөнгүй дурсгал Баянхонгор аймгийн нутгаас илэрсэн байна. Үүүнд, эртний түрэг, уйгурын үед холбогдох Гурванмандалын бичээс (Болд, Бямбаа 2004: 174-182; Баттулга 2004: 174-182), Бөмбөгөрийн бичээс зэрэг руни бичгийн дурсгал (Баттулга 2003: 085-090), Манж Чин улын үед холбогдох Байдрагийн Залаатын амны нангиад бичээс (Баттулга 2005: 14-18) зэргийг дурдаж болно.

Далтын хадны зураг

Байршил: 47Т 0538460 UTM 5143116 (N 46°26'25,8" E 99°30'02,4") 1836m (Зураг 1).

Далт уул нь толигор гадаргатай хар, бор хүрмэн чулуун тогтоцтой бөгөөд уулын байц болон үхэр, хонин хаднаа ан амьтан, хүний зураг цөөнгүй дүрсэлжээ.

Далт уулнаа буй хадны зураг нь он цагийн хувьд ихэвчлэн хүрэл зэвсгийн үед хамаарагдах нь тодорхой байна. Хүрлийн үеийн хадны зурагт буга, хандгай, янгир, үхэр, адуу, аргаль, нохой, гахай зэрэг амьтад элбэг тохиолдох ба хүнийг дүрслэхдээ эрэгтэй хүний бэлгэ эрхтнийг онцлож, нум сум харваж буй байдлаар үзүүлсэн нь зонхилдог онцлогтой. Далт уулын хадны зурагт ч эдгээр дүрслэлүүд зонхилж байна.

Хүрэл зэвсгийн үеийн хадны зураг зурах гол аргын нэг болох амьтдыг дүрслэхдээ бүх биеэр нь хонхойлгон цохиж аргаар дүрсэлсэн зураг зонхилж байгаа бөгөөд амьтны биеийг хөвөөлөн цохих аргаар зурсан зураг ч мөн тохиолдож байна. Мөн түүнчлэн сараачин зурчих аргаар дүрсэлсэн зураг цөөн тоотой боловч тохиолдож байна.

Далтын хадны зурагт дүрслэгдсэн зарим зургийн талаар товч өгүүлбэл:

Янгир, аргал. Янгир, аргалийг дүрсэлсэн нь чулуун зэвсгийн үеэс эхлэлтэй бөгөөд хүрэл, төмрийн түрүү үе, хүннү, түрэг зэрэг түүхэн үеүүдэд мөн л дүрсэлсээр иржээ. Далт уулын хаднаа дүрслэгдсэн янгир, аргалийн дүрс нь он цагийн хувьд хүрэл зэвсгийн үед холбогдох нь тодорхой байна.

Далтын хадны зурагт янгирыг ганц хоёроор нь мөн сүрэглэн яваа байдлаар дүрсэлсэн байх ба сүргээр яваа байдлаар дүрсэлсэн янгирын толгойг ихэвчлэн нэг зүг хандуулж зуржээ. Янгирын эврийг маш тодорхой үе гаргаж, хөлний хөдөлгөөнийг хүртэл маш уран нарийн хийцтэй дүрслэн үзүүлжээ. Далт уулын хаднаа янгирыг гүйж, харайж, дэгдэн цовхицож буй зэрэг олон үйл хөдлөлтэйгээр дүрсэлсэн тохиолдож байна. Аргалийг том даргар эвэртэйгээр ганц, нэгээрээ зогсож буй байдалтайгаар дүрсэлжээ (Зураг 2).

Буга. Хүрэл зэвсгийн үеийн хадны зургийн хамгийн сонгодог төлөөлөл нь бугын дүрс билээ. Хадны зургийн судалгааны бүтээлүүдээс үзэхэд бугын хийсвэрлэсэн дүрс нийтийн тооллын өмнөх II мянганы дунд үед холбогдох ажээ.

Далт уулын хаднаа бугыг толгойноос дээш гарсан ганц том эврээс олон салаа салаалж гарсан байдалтайгаар дүрсэлсэн байна (Зураг 2).

Үхэр. Монголын төв нутгийн хадны зурагт үхэр дүрсэлсэн нь харьцангуй цөөн, харин баруун бүс нутгийн хадны зурагт үхэр дүрсэлсэн зураг харьцангуй олон тохиолддог ажээ (Батболд 2011). Далт уулын хаднаа үхрийг том гэдэстэй, гозгор эвэртэй, урт сүүлтэй, зогсож буй байдлаар дүрсэлсэн байх ба эр хүйсийг тодорхой харуулсан байна (Зураг 3).

Махчин амьтан. Далт уулын хаданд хэд хэдэн янзын махчин амьтдыг дүрсэлсэн харагдаж байв. Үүнд, чоныг унжсан сүүлтэй, соотон чихтэйгээр, янгирын араас хөөж буй болон барьж буйгаар дүрсэлснээс гадна ирвэс бололтой урт сүүлтэй нарийн биетэй амьтныг бас дүрсэлсэн тохиолдож байлаа (Зураг 3, 4).

Хүний дүрс. Хүрлийн үеийн хадны зургийн нэгэн онцлог нь хүний дүр, дүрслэл билээ. Нум сум харван ан ангаж буйгаар дүрсэлсэн зураг зонхилох боловч мөн эсрэгцэн зогсож бие биенээ нум сумаар харваж буйгаар дүрсэлсэн ч цөөнгүй байдаг. Эрэгтэй хүний бэлэг эрхтнийг товойлгон үзүүлэх нь энэ үеийн хадны зургийн гол дүрслэлийн нэг яах аргагүй мөн билээ. Далтын хадны зурагт хөлтэйгээ тэнцэхүйц урт бэлэг эрхтэй хүн, нум сумаар ан агнаж буй хүний зураг зонхилж байна. Харин хүрлийн үеийн хүн дүрсэлсэн хадны зурагт олонтоо тохиолддог эр эм

хурьцаж буйг дүрсэлсэн зураг бид энэ удаагийн гүймэг судалгааны хүрээнд үзээгүй болно (Зураг 5).

Хэдийгээр хадны зургийн бусад дурсгалуудаас ялгарах онцгой, өвөрмөц дүр дүрслэлгүй ч Далтын хадны зургийг Монголын хадны зургийн бүртгэлд оруулж тухайлан судлах нь зүйтэй болов уу.

Эртний бичээс

Руни бичгийн байршил:

47T 0538472 UTM 5143107 (N 46°26'25,7" E 99°30'03,0") 1837m

Далт уулнаа зураг бүхий хадтай толгойд нэгэн хадан дээр руни бичээс буйг илрүүллээ (Зураг 6). Уг бичээс нийт 5 үсэг тэмдэгтээс бүрдэх ба бичээсийн урт 11 см, өндөр нь 4-6 см. Бичээсийн доор үл ойлгогдох дүрсийг үзүүртэй зүйлээр сараачин зуржээ. Энэ нь уг бичээснээ холбогдолгүй бололтой.

Далт хэмээх уулнаас илрүүлсэн руни бичгээрх ганц үг болно.

Уг ганц үг нь **ᠠᠨᠴᠢᠷ** гэсэн таван тэмдэгт буюу k ü nᠴ i r гэх дөрвөн дан, нэг нийлмэл тэмдэгтээс бүрэлдэж байна.

Энэ ганц үгийг дөрвөн хувилбараар уншиж болно. Үүнд:

künᠴir

kü anᠴi er

kü anᠴir

künᠴi er

Нэг. Уг бичээсийг **künᠴir** хэмээн уншвал нэгэн хүний нэр дурдагдаж байна хэмээн үзэх боломжтой. Өөрөөр хэлбэл “Күнчир” гэх нэгэн нэрээ бичиж үлджээ гэж болно.

Хоёр. Харин “**kü anᠴi er**” хэмээн уншвал нэг өгүүлбэр буюу нэг цогц санааг илэрхийлсэн гэж үзэх боломжтой. **kü** (ᠬᠦ) нь алдар цуу гэсэн утгатай үг болох нь тодорхой билээ. Монгол нутгаас олдсон руни бичгийн сонгодог дурсгалуудад олонтоо тохиолддог бөгөөд тухайлбал Көлтигин, Келичур гэх үгсийн язгуур үндэс болох **kü** (ᠬᠦ) мөн билээ. Хоёрдугаар үг болох **anᠴi** (ᠠᠨᠴᠢ) нь **anᠴa** гэх үгийн бичлэгийн нэгэн хувилбар байж болох юм.

Төгсгөлийн **er** (ᠡᠷ) нь “эр, цэрэг” гэсэн үг бөгөөд мөн “баатар, дайчин” гэсэн утгаар руни бичгийн дурсгалуудад тохиолддог. Дээрх үгсийн нэгтгэн уншвал “**Цуутай (алдартай) тийм баатар (билээ)**” буюу утгачилж буулгавал “**Тийм их алдар цуут баатар**” гэсэн утгатай бичээс болж байна.

Гурав. Руни бичгийн дээрх ганц мөр бичээсийг kü anᠴir хэмээн уншиж бас болох байна. Тэгвэл “**Цуутай (алдартай) Анчир**” гэх бичээс болох бөгөөд алдар цуутай Анчир хэмээх хүний алдрыг тэмдэглэн үлдээжээ гэж үзэж болно.

Дөрөв. Мөн бичээсийг **künci er** хэмээн уншиж болох байна. Ийнхүү уншвал “**künci**” нь цол хэргэм буюу эсвээс уг хүний овгийн нэр байж болно.

Хэрвээ “**күнчи**” гэдгийг цол хэргэм гэж үзвэл уг бичээсийг “**Күнчи цолт эр (баатар)**” гэсэн утгатай хэмээн тайлж болно. Харин овог аймгийн нэр гэж үзвэл “**Күнчи овгийн (аймгийн) эр (баатар)**” гэсэн утгатай бичээс болно.

Цаашид эрдэмтэд дахин нягтлан судалж эл дөрвөн хувилбар уншлагын аль нь зөв болохыг тодруулах буй за.

ТАЛАРХАЛ

Энэхүү хээрийн хайгуул судалгааг “Том шижир” ХХК-ий санхүүжилтээр гүйцэтгэлээ. Археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлсэн Том шижир ХХК-ий захирал Алтайсайханд талархсанаа илэрхийлье.

НОМЗҮЙ

- Баттулга Ц*, 2004. Гурванмандалын бичээсийг дахин нягтлах нь, -ШУА, Археологийн хүрээлэн, Археологийн судлал, том II (XXII), fasc.15, Улаанбаатар, 174-182 дугаар тал.
- Баттулга Ц*, 2003. Бөмбөгөрийн бичээс, -Centre for Mongol Studies, National University of Mongolia, Acta Mongolica, Volume. 2 (208), Улаанбаатар, 085-090 дугаар тал.
- Баттулга Ц*, *Бадмаанямбуу Д*, 2005. Байдрагийн Залаатын амны нангиад бичээс, - Үндэсний монгол судлал, №5, Улаанбаатар, 14-18 дугаар тал
- Баяр Д*, 1996. Гурван Мандалын хадны зураг. SA. Т. ХҮI, f. 7, УБ, х. 89-102
- Болд Л*, *Бямбаа Р*, 1988. Гурван Мандалын түрэг бичээс, -Дорно дахин судлалын асуудал, Улаанбаатар, №1 (18), тал.103-108.
- Волков В.В.* 1980. Курганы афанасьевского типа в Монголии. SA. Т. IX, f. 2, УБ. х. 13-16.
- Гүнчинсүрэн Б.* 1995. Зуухын суурингийн ялтас болон ялтсан төрлийн зэвсэг. SA.
- Гүнчинсүрэн Б.*, *Гантулга Ж.*, *Базаргүр Д.*, *Хатанбаатар П.*, *Марколонго Б.*, *Марколонго Ф.* 2010. Орог нуур орчимд хийсэн археологийн малтлага судалгааны урьдчилсан үр дүнгээс. SA. Т. XXIX, f. 7, х. 144-169.
- Гүнчинсүрэн Б.*, *Марколонго Б.*, *Базаргүр Д.*, *Гантулга Ж.*, *Амгалантөгс Ц.* 2006. Монгол-Италийн хамтарсан “Говийн гео-археологи” төслийн 2006 оны малтлага, хайгуул судалгааны ажлын тайлан. Улаанбаатар. АХГБС
- Гүнчинсүрэн Б.*, *Марколонго Б.*, *Пужетта М.*, *Базаргүр Д.*, *Болорбат Ц.* 2005. Түрэгийн үед холбогдох хоёр булшны тухай. SA. Т. XXIII, f. 7. УБ, х. 104-112
- Деревянко А.П.*, *Дорж Д.*, *Васильевский Р.С.*, *Ларичев В.Е.*, *Петрин В.Т.*, *Цэвээндорж Д.* 1986. Археологические исследования в Монголии в 1985 г. Новосибирск
- Деревянко А.П.*, *Цэвээндорж Д.*, *Олсен Дж.*, и др. 1996. Археологические исследования Российско-Монгольско-Американской экспедиции в Монголии в 1995 г. Новосибирск.
- Деревянко А.П.*, *Олсен Дж.*, *Цэвээндорж Д.* 1998. Археологические исследования Российско-Монгольско-Американской экспедиции в Монголии в 1996 году. Новосибирск. с. 56-57
- Дорж Д.* 1990. Каменный век Монголии. Новосибирск.
- Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал (Сэдэвчилсэн лавлах).* 1999. Улаанбаатар, х. 99
- Сэр-Оджав Н.* 1987. Баянлигийн хадны зураг. УБ.

ДАЛТЫН ХАДНЫ ЗУРАГ, ЭРТНИЙ БИЧЭЭС

Хүрэлсүх С., Амгалантөгс Ц., Фролич Б. 2011. Баянхонгор аймгаас олдсон хадны оршуулгууд. SA. Т. XXX, f. 13, УБ. х. 233-142

Цэвээндорж Д. 1979. 1979 оны МЗТСХЭ-ийн палеолитийн дурсгал судлах ангийн тайлан. ТХГБС.


Цэвээндорж Д., Цэрэндагва Я. 2005. Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрээс олдсон хадны зургийн зарим дурсгалаас. SA. Т. XXIII, f. 2, УБ., х. 16-31



Зураг 1. Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын нутаг Далт уулын хадны зураг бүхий хэсэг



Зураг 2. Далт уулын хаданд дүрсэлсэн янгир, аргаль, олон салаа эвэртэй буга



Зураг 3. Далт уулын хаданд дүрсэлсэн үхэр чонын дүрс



Зураг 4. Далтын талбайн хадны зураг. Янгирын сүрэг, аргал, махчин амьтан



Зураг 5. Далт уулын хаданд дүрсэлсэн ан хийж буй хүн, янгир



Зураг 6. Далтын ууланд олдсон руни бичээс